



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/145/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дорноговь аймаг, Сайншанд сум  
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 99092469 Цахим хаяг: .....  
Аудитын менежер: Э.Энхцэцэг  
Утас: 90077079 Цахим хаяг: .....  
Аудитор: Э.Батчимэг  
Утас: 99032916 Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

## Товчилсон үгийн жагсаалт


УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Уран нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 2019.02.26 № 1-6/209 Танай _____ -ны № _____ -т	<b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА</b>
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Өлзийбүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 13-наас 2019 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь Хүүхэд залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, хамгааллын үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Гэрч , хохирогчийг хамгаалах тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөрчлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт , өөрчлөлт гараагүй

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн ""Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны Нийт зардал 325,274.8 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 654.02 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	2,210.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	21,693.90	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	23,904.20	

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал**

Автомашин худалдаж авахаар 21,000,000.0 төгрөг шилжүүлэн авлагаар бүртгэсэн.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

**2.8.1.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

2018.10.04-нд хэзээ байгуулсан нь мэдэгдэхгүй гэрээний төлбөрт Б.Бат-Өлзий, Т.Мандухай нарт тус бүр 320,0 мянган төгрөг анхан шатны баримтгүй олгосон байна. Мөн Мобиком ХХК-д 20,0 мянган төгрөг, Монос Дорноговь ХХК-д 33.9 мянган анхан шатны баримтгүй төлсөн байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 368,764.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 304,619.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсөв 4,144.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийн хувьд 2018 оны жилийн эцсийн байдлаар нэг зөвлөмж өгсөн бөгөөд биелэлт 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн тайлангаар 2,199.6 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна.
2. Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа ХЧТА-н тэтгэмжээс ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

#### 3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаар 2,199.6 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Авлага, өглөгийг барагдуулаагүй байх

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага , өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

### **3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин**

#### 3.2.1 Илрүүлэлт:

Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа ХЧТА-н тэтгэмжээс ХХОАТ гэж 10%-г суутгасан

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС,ХХОАТ-ын тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө" 16 дугаар зүйлийн 16.1.1 "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

## **4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

дүнг	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>62,391,188.66</b>	<b>108,618,462.80</b>
33	<b>АВЛАГА</b>	5,263,507.86	21,000,000.00
335	Бусад авлага	5,263,507.86	21,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	4,750,507.86	400,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	513,000.00	20,600,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	57,127,680.80	87,618,462.80
354	Хангамжийн материал	57,127,680.80	87,618,462.80
35410	Бичиг хэргийн материал	5,090,967.00	5,090,967.00
35420	Аж ахуйн материал	52,036,713.80	82,527,495.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>767,624,477.97</b>	<b>1,079,349,895.39</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	767,624,477.97	1,079,349,895.39
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	767,624,477.97	1,043,349,895.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	858,498,485.00	885,820,823.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(150,672,008.89)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,333,333.16)	(30,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,407,420.18	273,455,958.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(139,569,776.25)	(141,610,117.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,339,513.54	59,578,773.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,441,655.99)	(37,567,688.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,186,900.00	6,172,145.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,791,066.46)	(2,500,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		36,000,000.00
39301	Програм хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(917,500.00)	(917,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		36,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>830,015,666.63</b>	<b>1,187,968,358.19</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,274,599.00</b>	<b>2,199,600.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,274,599.00	2,199,600.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,274,599.00	2,199,600.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,249,399.00	2,159,600.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	25,200.00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		40,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		40,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>828,741,067.63</b>	<b>1,185,768,758.19</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	828,741,067.63	1,185,768,758.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	929,074,695.17	965,074,695.17
51101	Өмч: - төрийн	929,074,695.17	965,074,695.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(193,122,696.38)	(74,657,870.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	(193,122,696.38)	(192,556,604.72)
51220	Тайлант үеийн үр дүн	-	117,898,734.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,789,068.84	295,351,933.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>830,015,666.63</b>	<b>1,187,968,358.19</b>

441714435,  
EICA0056 002570

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>159,541,351.68</b>	<b>444,908,202.00</b>
12	<b>ТАТВАРЫН БҮС ОРЛОГО</b>	<b>9,166,000.00</b>	<b>149,994,002.00</b>
120	Нийтлэг татварын бүс орлого	9,166,000.00	149,994,002.00
120004	Төсөн байгууллагуудын өөрийн орлого	9,166,000.00	149,994,002.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,966,000.00	8,005,000.00
1200045	Үнэ төлбөргүй хулээн авсан орлого	2,200,000.00	141,989,002.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>148,583,125.00</b>	<b>294,914,200.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	105,295,500.00	195,701,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,295,500.00	195,701,900.00
131007	Тусгай зорималтын шилжүүлэгээс санхүүжих	1,792,226.68	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,287,625.00	99,212,300.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагууд авч хөнгөлөлттэй зээл	32,455,120.00	100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй ноцд хөрөнгөөс тухайн төсвийн захиргагчид хуваарилсан хөрөнгө	10,832,505.00	97,612,300.00
131105	Төсвийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бей болсон нэмэлт орлого		1,500,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>161,048,805.98</b>	<b>325,274,791.85</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>161,048,805.98</b>	<b>325,274,791.85</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>135,048,805.98</b>	<b>323,024,734.85</b>
2101	Цалин хала болон нэмэгдэл урамшил	54,607,423.00	114,459,443.00
210101	Үндсэн цалин	54,607,423.00	114,459,443.00
2102	Ажил олгогчоос нийгэмийн даатгал төлөх шимтгэл	6,209,213.00	14,728,144.68
210201	Тэтгэврийн даатгал	4,104,592.00	9,949,455.00
210202	Тэтгэмжийн даатгал	436,589.00	1,146,403.00
210203	УСМШЭ-ийн даатгал	498,872.00	978,163.00
210204	Ажилгүйдлийн даатгал	113,888.00	323,605.00
210205	Эрүүд мэндийн даатгал	1,055,272.00	2,330,518.68
2103	Байр ашиглалттай халбоотой тогтмол зардал	13,873,549.00	24,514,491.00
210301	Гэрэл, цахилгаан	2,830,457.00	3,618,859.00
210302	Түлш, халалт	9,889,760.00	17,276,364.00
210303	Цахир, бохир ус	1,153,332.00	3,619,268.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,092,396.00	7,752,964.50
210401	Бичиг хэргэ	430,790.00	1,940,843.00
210402	Тээвэр, шатахуун	166,240.00	3,187,143.50
210403	Шуудан, халабоо, янтрэгээний төлбөр	377,166.00	1,108,624.00
210406	Бага үнэтэй, тургэн хэлгэх, ахуйн эд зүйлс	118,200.00	1,516,354.00
2105	Нормативт зардал	21,880,960.00	
210502	Хоол, хүнс	21,880,960.00	
2106	Эд зөвшил, урсгал засварын зардал		9,905,549.68
210601	Багаж, техник, хэргэсэл		40,000.00
210604	Урсгал засвар		9,865,549.68
2107	Томилголт, зочны зардал	360,000.00	7,528,200.00
210702	Дотоод албан томилолт	360,000.00	7,528,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,500.00	24,148,687.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	23,618,687.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгцээ тогтоох		160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар		370,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,665,764.98	119,987,254.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,999,900.00	12,148,750.00
210902	Хячгээ үйлдвэрлэлийн далагга хийх	7,051,590.00	61,576,942.00
210903	Үндсэн хөрөнгийн эзлэгээ, хорогдол	21,614,274.98	46,261,562.99
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,000,000.00</b>	<b>2,250,057.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,000,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,250,057.00
213303	Төлбөрүүлэх шилжүүлэг		2,250,057.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)-(1)-(2)</b>	<b>(1,507,454.30)</b>	<b>119,633,410.15</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>1,734,675.44</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,734,675.44
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)-(145-225)</b>		<b>(1,734,675.34)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)-(3)+(4)</b>	<b>(1,507,454.30)</b>	<b>117,898,734.71</b>

4417144353  
EIOAD050 802570

СТ-3А

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>157,341,351.68</b>	<b>306,869,699.68</b>
12	<b>ТАТВАРЫН БҮС ОРЛОГО</b>	<b>6,966,000.00</b>	<b>11,955,499.68</b>
120	<b>Нийтлэг татварын бүс орлого</b>	<b>6,966,000.00</b>	<b>8,005,000.00</b>
120004	<b>Төсөн байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,966,000.00</b>	<b>8,005,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,966,000.00	8,005,000.00
123	<b>Улсын төсвө орон нутгийн төсвө зорилгын шилжүүлэг</b>		<b>3,950,499.68</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		3,950,499.68
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>150,375,351.68</b>	<b>294,914,200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>105,295,500.00</b>	<b>195,701,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,295,500.00	195,701,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,792,226.68	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>43,287,625.00</b>	<b>99,212,300.00</b>
131102	Төсвийн жилийн явдал УИХ-аас сонирхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болов ОУ байгууллагаас авах хэлэлцэлтэй зээл	32,455,120.00	100,000.00
131103	ЗНХ,ЗДНХоронго,түүнтэй адилтгах ангиллагдаагүй нөхцө хөрөнгөөс тухайн төсвийн засагчид хувиарласан хөрөнгө	10,832,505.00	97,612,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,500,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>139,275,071.00</b>	<b>306,869,699.68</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>139,275,071.00</b>	<b>306,869,699.68</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>113,275,071.00</b>	<b>304,619,642.68</b>
2101	<b>Цалин халамь болон нэмэгдэл урамшил</b>	<b>54,607,423.00</b>	<b>112,827,844.00</b>
210101	Үндсэн цалин	54,607,423.00	112,827,844.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,209,213.00</b>	<b>14,164,100.00</b>
210201	Тэтгэрийн даатгал	4,104,992.00	9,029,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	436,589.00	1,128,600.00
210203	УОМЦӨ-ний даатгал	498,875.00	902,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	77,927.00	226,000.00
210205	Эрүүд мэдцийн даатгал	1,091,230.00	2,877,600.00
2103	<b>Байр ашигдалттай халамжийн төгтмөл зардал</b>	<b>13,873,549.00</b>	<b>24,514,491.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,830,457.00	3,618,859.00
210302	Тусал, халамт	9,889,760.00	17,276,364.00
210303	Цэвэр, бохир ус	1,153,332.00	3,619,268.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,092,396.00</b>	<b>7,680,808.00</b>
210401	Бөнгө хэрэг	437,390.00	1,729,843.00
210402	Тээвэр, шатахуун	166,240.00	2,723,250.00
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	370,566.00	1,108,624.00
210406	Бусад үйлдлийн, түргэн элсгэх, ахуйн эд зүйлс	118,200.00	2,119,091.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>21,880,960.00</b>	
210502	Хоол, хүнс	21,880,960.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>34,122,929.68</b>
210601	Багаж, төсний, хэрэгсэл		26,848,590.00
210604	Урсгал засвар		7,274,349.68
2107	<b>Томьёолт, зочны зардал</b>	<b>560,000.00</b>	<b>7,612,800.00</b>
210702	Дотоод албан томьёолт	560,000.00	7,612,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>359,500.00</b>	<b>26,638,426.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	26,108,426.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар		370,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,892,030.00</b>	<b>77,058,244.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,544,440.00	13,673,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даалгач хийх	6,347,590.00	63,384,534.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,000,000.00</b>	<b>2,250,057.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,000,000.00</b>	
213207	Тэтгээрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,000,000.00	
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>2,250,057.00</b>
213303	Төлвөрүүлэх шилжүүлэг		2,250,057.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>18,066,280.68</b>	
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>18,066,280.68</b>	
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн төсвийн үлдэгдэл</b>	<b>18,066,280.68</b>	

4417144355  
E:\O\0058 902578

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	929,074,695.17	92,789,068.84	(191,615,242.08)		830,248,521.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	929,074,695.17	92,789,068.84	(191,615,242.08)		830,248,521.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлагт үеийн үр дүн			(1,507,454.30)		(1,507,454.30)
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	929,074,695.17	92,789,068.84	(193,122,696.38)		828,741,067.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			566,091.66		566,091.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	929,074,695.17	92,789,068.84	(192,556,604.72)		829,307,159.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		202,562,864.19			202,562,864.19
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлагт үеийн үр дүн	36,000,000.00		117,898,734.71		153,898,734.71
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	965,074,695.17	295,351,933.03	(74,657,870.01)		1,185,768,758.19



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эзний зэвсгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хуь
		Батлагдсан талынлогоо	Гүйцэтгэл		
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	203,701,900.00	202,048,469.00	1,653,431.00	99.2%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	203,701,900.00	202,048,469.00	1,653,431.00	99.2%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЭГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	203,701,900.00	202,048,469.00	1,653,431.00	99.2%
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	112,865,600.00	112,827,844.00	37,756.00	100.0%
210101	Үндсэн цалин	112,865,600.00	112,827,844.00	37,756.00	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөв шимтгэл	14,164,100.00	14,164,100.00		100.0%
210201	Тэтгэрийн даатгал	9,029,000.00	9,029,000.00		100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	1,128,600.00	1,128,600.00		100.0%
210203	ҮОМШО-ний даатгал	902,900.00	902,900.00		100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	226,000.00	226,000.00		100.0%
210205	Эрүүд мэндийн даатгал	2,877,600.00	2,877,600.00		100.0%
2103	Бэйр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,064,200.00	24,514,491.00	549,709.00	97.8%
210301	Гэрэл, цахилгаан	4,164,700.00	3,618,859.00	545,841.00	86.9%
210302	Түлш, халвалт	17,277,200.00	17,276,364.00	836.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	3,622,300.00	3,619,268.00	3,032.00	99.9%
2104	Хянгамж, бараа материалын зардал	6,270,900.00	6,263,808.00	7,092.00	99.9%
210401	Бичиг хэрэг	1,656,500.00	1,729,843.00	(73,343.00)	104.4%
210402	Тээвэр, шатахуун	1,306,900.00	1,306,250.00	650.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	1,307,500.00	1,108,624.00	198,876.00	84.8%
210406	Бага үнэтэй, тургэн зоглох, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,119,091.00	(119,091.00)	106.0%
2106	Эд хогшиа, урсгал засварын зардал	11,700,000.00	11,598,390.00	101,610.00	99.1%
210601	Багаж, техник, хэргэгэл	7,000,000.00	6,998,580.00	1,420.00	100.0%
210604	Урсгал засвар	4,700,000.00	4,599,810.00	100,190.00	97.9%
2107	Томилгог, зочны зардал	1,517,000.00	1,330,600.00	186,400.00	87.7%
210702	Дотоод албан томилгог	1,517,000.00	1,330,600.00	186,400.00	87.7%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,063,300.00	22,298,186.00	765,114.00	96.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,493,300.00	21,768,186.00	725,114.00	96.8%
210802	Аудит, баталгаажуулалт, хэрэгэлт татгоох	200,000.00	160,000.00	40,000.00	80.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,000.00	370,000.00		100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,056,800.00	9,051,050.00	5,750.00	99.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,735,300.00	4,729,550.00	5,750.00	99.9%
210902	Хөгжөл үйлдвэрлэлийн далаага хийх	4,321,500.00	4,321,500.00		100.0%
	<b>ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	203,701,900.00	203,706,900.00	(5,000.00)	100.0%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	195,701,900.00	195,701,900.00		100.0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	195,701,900.00	195,701,900.00		100.0%
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНААС</b>	8,000,000.00	8,005,000.00	(5,000.00)	100.1%
1200041	Үндсэн үйлжиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	8,005,000.00	(5,000.00)	100.1%
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	19.00	20.00	(1.00)	105.3%
620001	Улирдах ажилтан	1.00	1.00		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	10.00	(3.00)	142.9%
620003	Үйлчлэх ажилтан	11.00	9.00	2.00	81.8%
620004	Гэрээт ажилтан				
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>				
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>				
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>				
632	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>				
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>				
65	<b>ОРОН ТООНЫ МЭДСЭЛЭЛ</b>				

4417144353  
EHOA0056 902578

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ тэгшгөөр /

Данси	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	<b>ИНИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЭЭЛИЙН ДҮН</b>	<b>105,062,499.68</b>	<b>102,571,173.68</b>	2,491,326.00	97.6%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>105,062,499.68</b>	<b>102,571,173.68</b>	2,491,326.00	97.6%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>105,062,499.68</b>	<b>102,571,173.68</b>	2,491,326.00	97.6%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,417,000.00	1,417,000.00		100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,417,000.00	1,417,000.00		100.0%
2106	Эл хогшил, урсгал засварын зардал	22,755,299.68	22,524,539.68	230,760.00	99.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,850,000.00	19,850,000.00		100.0%
210604	Урсгал засвар	2,905,299.68	2,674,539.68	230,760.00	92.1%
2107	Томилгоот, зочны зардал	6,282,200.00	6,282,200.00		100.0%
210702	Дотоод албан томилгоот	6,282,200.00	6,282,200.00		100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,366,000.00	4,340,240.00	25,760.00	99.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,366,000.00	4,340,240.00	25,760.00	99.4%
2109	Барив үйлчилгээний бусад зардал	70,242,000.00	68,007,194.00	2,234,806.00	96.8%
210901	Барив үйлчилгээний бусад зардал	8,978,200.00	8,944,160.00	34,040.00	99.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,263,800.00	59,063,034.00	2,200,766.00	96.4%
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>105,062,499.68</b>	<b>99,212,300.00</b>	<b>5,850,199.68</b>	<b>94.4%</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>105,062,499.68</b>	<b>99,212,300.00</b>	<b>5,850,199.68</b>	<b>94.4%</b>
131102	Төсвийн ажилын явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хандлагатай тээл		100,000.00	(100,000.00)	
131103	ЗГНХ,ЗДНХоронго,түүнтэй адилтгах ангилалдгүй өнөө хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,200,000.00	97,612,300.00	(19,412,300.00)	124.8%
131104	Дээд шатны төсвийн захирагчид тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,412,000.00		21,412,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,000.00	1,500,000.00		100.0%
131106	Төсвийн урамшуулал	3,950,499.68		3,950,499.68	
IV	<b>ИНИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

4417144353  
ENC00058 8025707